

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр
төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтод үр дүн 70.7 хувьтай байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Орон нутгийн хөгжлийн сангийн
бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн

АУДИТЫН КОД: БНА-2022/30-ШТА-ГА

Чойбалсан хот 2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ 1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, сумдад хуваарилсан байна.....	5-11
1.1.1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.....	5-6
1.1.2. Аймгийн хэмжээнд 9 сум Малын тоо толгойн албан татвараас орох орлогыг төлөвлөж, батлаагүй байна.....	6-7
1.2.1. ОНХС-гийн журамд заасан сумын төвөөс алслагдсан багаас ирүүлсэн хамгийн өндөр санал авсан төсөл арга хэмжээг ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад оруулаагүй 3 сум байна.....	7-8
1.2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна.....	8-9
1.2.3. Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт, ажлын байр бий болгох чиг үүргүүдийн хэрэгжилт 0.7-1.1 хувийг эзэлж байна.....	10
1.2.4. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөөгүй 4 төсөл арга хэмжээ байна.....	10-11
БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтод үр дүн 70.7 хувьтай байна.....	11-15
2.1.1 ОНХС-гийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны 6.0 хувийг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.....	11-13
2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасан зориулалтын дагуу зарцуулсан байна.....	13-14
2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс зорилтод түвшин, үр дүнд хүрээгүй 81 төсөл, арга хэмжээ байна.....	14
2.2.2. ОНХС-гийн төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт 70.7 хувийн үр дүнтэй байна.....	14-15
2.3.1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийт хөрөнгийн 2.3 хувь нь ашиглагдахгүй байна.....	15
2.3.2. Матад суманд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хамгаалалтгүй 2 хөрөнгө байна.....	15
БҮЛЭГ 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг тайлагнасан ч хяналтыг бүрэн тавьж ажиллаагүй байна.....	16-18
3.1.1 ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 51 хувьд ИТХ-аас хяналт тавьж ажиллаагүй байна.....	16
3.1.2. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.....	16-17
3.1.3. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.....	17
3.2.1 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.....	18
3.2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 148 ширхэг 9,401.9 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна.....	18
3.2.3. Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн төсөл арга, хэмжээний 51.1 хувийг ОНХС-гийн удирдлагын мэдээллийн системд мэдээлээгүй байна.....	18
3.2.4. Шилэн дансны цахим хуудсанд аймгийн 14 сумаас 2 сум ОНХС-гийн мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй байна.....	19
Дүгнэлт:.....	19
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	20
ЗӨВЛӨМЖ:.....	21
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....	22-23

Товчилсон үгийн тайлбар

ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
MNS	Mongolian national standard
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд: • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	ОНХС-гийн 2021 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, аймаг, сумын ИТХ, ЗДТГ, баг, хороодын ИНХ, Засаг даргыг хамруулан шалгасан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит, Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, МҮЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан МҮЕА-ын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, сорил асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв. Аудитын талбарын ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 5 дугаар сарын 23-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, тайланг 6 дугаар сарын 02-нд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

БҮЛЭГ 1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, сумдад хуваарилсан байна.

1.1. Аймгийн ОНХС-гийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1.1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар ОНХС-гаас Дорнод аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 9,205.8 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 6/03 дугаар тогтоолоор баталсан төсвийн тодотголоор орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг ОНХС-гаас 9,205.8 сая төгрөг, уул уурхайн хандив тусламжаас 3,892.0 сая төгрөг нийт 13,097.8 сая төгрөгийн санхүүжилтээр бүрдүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн нийт 13,097.8 сая төгрөгийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал"-д заасны дагуу аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсээс сумдад дараах байдлаар хуваарилсан байна.

ОНХС-гаас санхүүжилт 9,205.8 сая төгрөгөөс тогтвортой амьжиргаа төслийн эх үүсвэр 678.1 сая төгрөг, орон нутгийн суурь зарлага 500.0 сая төгрөгийг хасаж 8,027.7 сая төгрөгийн 33.4 хувь болох 2,681.8 сая төгрөг, уул уурхайн хандив тусламжийн 3,892.0 сая төгрөгийн орлогоос 30 хувь буюу 1,167.6 сая төгрөг нийт 3,849.4 сая төгрөгийг сумдад тус тус хуваарилсан байна.

Аймгийн ИТХ аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 2021 оны 6/03 дугаар тогтоолоор баталсан байна.

Хүснэгт 1. "аймаг, сумдын ОНХС-гийн орлогын шилжүүлэг"

д/д	Сумдын нэр	ОНХС санхүүжилт /сая.төг/	/тогтвортой амьжиргаа- 3 төсөл/ /сая.төг/	ОНХНС нийт дүн /сая.төг/	Уул уурхайн хандив тусламжийн орлого	Бүгд
1	Баяндун	173.7	44.8	218.5	23.7	242.2
2	Баянтүмэн	157.7	23.4	181.1	46.7	227.7
3	Баян-Уул	153.2	59.7	212.8	-	212.8
4	Булган	58.4	22.2	80.6	10.0	90.6
5	Гурванзагал	88.0	25.2	113.2	-	113.2
6	Дашбалбар	658.8	34.5	693.3	317.5	1,010.8
7	Матад	209.0	62.1	271.1	218.3	489.4
8	Сэргэлэн	47.4	19.0	66.4	96.4	162.9
9	Халхгол	309.1	97.3	406.4	213.3	619.7
10	Хөлөнбуйр	52.4	21.6	74.0	-	74.0
11	Хэрлэн	368.5	156.2	524.6	16.7	541.3
12	Цагаан-Овоо	150.3	39.5	189.9	225.0	414.9
13	Чойбалсан	157.9	38.4	196.4	-	196.4
14	Чулуунхороот	97.5	34.2	131.6	-	131.6
	Сумдын дүн	2,681.8	678.1	3,359.9	1,167.6	4,527.5

	Аймаг	5,845.9	-	5,845.9	2,724.4	8,570.3
	Нийт дүн	8,527.7	678.1	9,205.8	3,892.0	13,097.8

Эх сурвалж: аймгийн ИТХ-ын 2021 оны 6/03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

1.1.2. Аймгийн хэмжээнд 9 сум Малын тоо толгойн албан татвараас орох орлогыг төлөвлөж, батлаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэхээр заасан. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг,
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр,
- Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг
- Малын тоо толгойн албан татварын орлого,

Аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 60.2.5-д заасны дагуу ОНХС-гийн эх үүсвэрийг судлан 2021 онд уул уурхайн хандив тусламжаас орох орлогыг 3,892.0 сая төгрөгөөр төлөвлөн 3,967.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-д төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын хэмжээнд 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Малын тоо толгойн албан татварын тухай хуульд заасны дагуу аймгийн хэмжээнд 2021 онд малын тоо толгойн албан татвар 1,157.3 сая төгрөг төсөвт төвлөрсөн байна.

Хүснэгт 2. “малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө, гүйцэтгэл”

№	Сумын нэр	2021 он /сая.төг/	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баяндун	52.0	41.6
2	Баян-Уул	106.7	99.1
3	Баянтүмэн	0.0	126.3
4	Булган	0.0	96.8
5	Гурванзагал	0.0	63.8
6	Дашбалбар	20.0	134.2
7	Матад	0.0	146.9
8	Сэргэлэн	84.0	155.4
9	Халхгол	0.0	35.7
10	Хөлөнбуйр	0.0	44.3
11	Хэрлэн	0.0	47.5
12	Цагаан-Овоо	63.4	77.5
13	Чойбалсан	0.0	50.4
14	Чулуунхороот	0.0	37.8
		326.1	1,157.3

Эх сурвалж: аймгийн Татварын хэлтсийн судалгаа

Дорнод аймгийн сумдаас Баяндун, Баян-Уул, Дашбалбар, Сэргэлэн, Цагаан-Овоо сумд нь ОНХС-гийн эх үүсвэрт малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөн сумын ИТХ-аар батлуулсан байна.

Сумдын ИТХ-ын Малын тоо толгойн албан татвар тогтоосон тогтоол нь Захиргааны ерөнхий хуульд зааснаар нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актад бүртгэгдэх ёстой. Нийтээр дагаж мөрдөж захиргааны хэм хэмжээний актад бүртгэх хуулийн процесст хугацаа их зарцуулдаг тул Баянтүмэн, Булган, Гурванзагал, Матад, Халхгол, Хөлөнбуйр, Хэрлэн, Чойбалсан, Чулуунхороот сумд 2021 онд малын тоо толгойн орлогыг ОНХС-гийн орлогын эх үүсвэрт оруулан тооцоогүй байна.

1.2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна.

1.2.1. ОНХС-гийн журамд заасан сумын төвөөс алслагдсан багаас ирүүлсэн хамгийн өндөр санал авсан төсөл арга хэмжээг ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад оруулаагүй 3 сум байна.

Аймгийн хэмжээнд иргэд цахим болон цаасан хэлбэрээр ОНХС-д санал өгч оролцсон байна.

Хүснэгт № 3 "Иргэдийн саналын тоо"

№	Аймаг, сум	Санал өгсөн иргэний тоо	Саналын хэлбэр
1	Баяндун	1,298	Саналын хуудас
2	Баянтүмэн	3,648	Саналын хуудас
3	Баян-Уул	7,190	Саналын хуудас
4	Булган	809	Саналын хуудас
5	Гурванзагал	2,029	Саналын хуудас
6	Дашбалбар	1,652	Саналын хуудас
7	Матад	3,391	Саналын хуудас
8	Сэргэлэн	1,060	Саналын хуудас
9	Халхгол	2,072	Саналын хуудас
10	Хөлөнбуйр	2,278	Саналын хуудас
11	Хэрлэн сум	16,994	Саналын хуудас /Цахим/
12	Цагаан-Овоо	4,451	Саналын хуудас
13	Чойбалсан	1,668	Саналын хуудас
14	Чулуунхороот	2,090	Саналын хуудас
	Нийт	50,630	

Эх сурвалж: www.onhs.mof.gov.mn

ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 3.1.4-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах;" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй 3 сум байна. Тухайлбал Хэрлэн, Баянтүмэн, Чойбалсан сумд нь сумын төвөөс алслагдсан багаас ирүүлсэн хамгийн өндөр санал авч ач холбогдлоороо нэгдүгээрт эрэмбэлэгдсэн төсөл арга хэмжээг 2021 оны төлөвлөгөөнд тусгаж батлаагүй байна.

Мөн аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлаагүй байна.

Аймгийн ОНХС-гийн ажлын хэсэг нь уг журмын 7.7 дахь заалт "ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна.

ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх 2021 онд хийгдсэн төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн хөгжлийн урт, дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байна. Үүнд:

- 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний - Хүний хөгжлийн бодлого, Эдийн засгийн бодлого, Сумдын хөгжлийн бодлого,
- Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн Хүний хөгжлийн бодлого, Орон нутгийн хөгжлийн бодлого,
- Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн Засаглал, Сум, Орон нутгийн хөгжлийн бодлого

Дорнод аймгийн хөгжлийн төлөвлөгөө, аймгийн ЗД-ын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлтэй уялдааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 4 “Хөгжлийн төлөвлөгөө, мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлийн үялдаа”

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тайлбар	Аймгийн 3Д-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн үндэс байгаа заалтаар	Дорнод аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдаж байгаа заалтаар	Дорнод аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаж байгаа заалтаар
1	Барилга, байгууламж, шинээр өмч бий болох	23	2.1.8Эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ 2.3.6.“Багийн бага сургууль” байгуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. 2.4.2.Аймгийн соёл урлагийн байгууллагын барилга байгууламжийг барих, засварлах, шаардлагатай тоног төхөөрөмж, үзмэр шинэчлэх, сумдад орон нутгаас суудах танхим шинээр бий болгох ажлыг үе шаттай зохион байгуулна. 2.4.5.Булан суман дахь Чингис хааны тахилын байгууламж “Тугийн сүм”-ийг сэргээн засварлаж барих ажлыг хэрэгжүүлнэ.	5.9.4. Сумдад ахуйн үйлчилгээний төв байгуулах, халуун усны барилга барих ажлыг хэрэгжүүлж, алслагдсан хөдөөгийн ирээдэд ахуй үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулна. 4.2.2. Хэрлэн сумын “Ивээл”, “Буйр” хороолол, Хан-Уул гудамжны эхний зэнээс дахин төлөвлөж барилгажуулах ажлыг эхлүүлнэ 4.3.2.Гэр хорооллын өрхийн газрыг ирээдүйн өөрсдийнх нь идэвх санаачилга, оролцоонд тулгуурлан дахин төлөвлөх, төлөвлөрсөн, хэсэчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлэх, ногоон байгууламж, тоглоомын талбайг нэмэгдүүлнэ.	2.1.2. Эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. 3.6.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нээмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, ирээдүйн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.
2	Барилга, байгууламжийн их засвар, өргөтгөл	64	6.2 Ирээдүйн ая тухтай, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд засвар, тохижилтын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. 3.5.2.Сум, суурин газарт төвлөрсөн дулааны эх үүсвэр шинээр барих, шугам сүлжээ өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, дулаан хангамжийн чанар хүртээмж, ард ирээдүйн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна. 3.5.2.3.Хэрлэн сумын гэр хороолол, үйлдвэрлэлийн бүс рүү дулааны шугам сүлжээ өргөтгөн барина.	6.1.7. Төрийн захирааны болон үйлчилгээний байгууллагуудын барилгын засвар, автомашины парк шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ. 8.1.7. “Аймаг, сумын бүсчилсэн хөгжлийн хөрөнөг оруулалт” төсөлтэй хамтран Чойбалсан хотод түүхийн дурсгалт барилга байгууламжийг засварлах, төмөр бетон гүүр барих, гэр хороололд инженерийн шугам сүлжээ барина.	2.4.Соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжих, үндэсний бахархал, уламжлалт өв соёлоо дээдэлж, ирээдүйг соён гэгээрүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. 3.2.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ. 3.6.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нээмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, ирээдүйн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. 6.1. Сумын хөгжлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэн ирээдүйн амьдралын чанарыг дээшлүүлнэ. 6.1.2. Хувийн хэвшлийн санаачлагыг дэмжих замаар сумдын халуун усны болон нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулна.
3	Тоног төхөөрөмж	30	2.1.Эрүүл мэндийн салбарт орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан хүн амын дундаж наслалтыг 72 жилд хүргэнэ. 5.3.2.Усны нөөц, чанарын хяналт-шинжилгээний байнгын, тасралтгүй сүлжээ ажиллуулж, усны хэрэглээний ухаалаг менежментийг үе шаттай хэрэгжүүлнэ. 6.2. Ирээдүйн ая тухтай, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд засвар, тохижилтын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	3.4.5. Хүмүүнлэгийн байгууллагын ирээдэд чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор тоног төхөөрөмж, автомашины парк шинэчлэлийг хийнэ. 3.4.14. Болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, гамшигийн онцгой нөхцөлийн үед шаардагдах тоног төхөөрөмж, бараа материалын нэр, төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж нөөцийг бүрдүүлэн, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.	6.1. Сумын хөгжлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэн ирээдүйн амьдралын чанарыг дээшлүүлнэ.
4	Зам, тайлбай, гэрэлтүүлэг	75	6.2. Ирээдүйн ая тухтай, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд засвар, тохижилтын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	4.3.2.Гэр хорооллын өрхийн газрыг ирээдүйн өөрсдийнх нь идэвх санаачилга, оролцоонд тулгуурлан дахин төлөвлөх, төлөвлөрсөн, хэсэчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлэх, ногоон байгууламж, тоглоомын талбайг нэмэгдүүлнэ 3.5.5. Аймаг, сумын төв дотор хатуу хучилттай авто зам, явган хүний, дугуйн зам барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. 8.1.1.Аймгийн төв, стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр зам, авто замуудыг барьж, тээвэр логистикийн төв байгуулах төслүүдийг хэрэгжүүлж, зам даасан газруудыг хөгжүүлнэ.	3.6.Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд сурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна. 6.1. Сумын хөгжлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэн ирээдүйн амьдралын чанарыг дээшлүүлнэ.
5	Усан хангамж	22	5.6. Байгаль орчны баяг хуулийн хэрэгжилтийг хангана 6.1.Сумын хөгжлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэн ирээдүйн амьдралын чанарыг дээшлүүлнэ. 6.2. Ирээдүйн ая тухтай, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд засвар, тохижилтын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Зорилт 7.2.Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлж гадаргын усны нөөцийг нэмэгдүүлнэ 3.5.4. Аймгийн төв, сум, суурин газарт үерийн далан суваг, борооны болон хөрсний ус цуглуулан зайлуулах байгууламж барина.	6.1. Сумын хөгжлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэн ирээдүйн амьдралын чанарыг дээшлүүлнэ
6	ТЭЗҮ	15	3.8.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нээмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, ирээдүйн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	Зорилт 4.2. Төр, иргэн хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалт менежментийг хариуцсан нэгжийг байгуулж, Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрыг дахин төлөвлөх ажлыг хэрэгжүүлнэ. 4.4.3. Аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зүй зохистой ашиглана. 5.4.1.Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоголх цэг, авто зам дагуу үйлчилгээний цэцэрлэгуудыг байгуулна. 8.1.9.Сумдыг эдийн засгийн ач холбогдолор нь бүсчлэн кластер загвараар хөгжүүлнэ.	3.5.Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.
7	Хөтөлбөр, төсөл арга хэмжээ	47	2.1.1. “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд эрүүл мэндийн салбарын зорилтыг хэрэгжүүлэхэд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулна. 2.2.Аймгийн хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлт 2019 оны жилийн эцэст 44.0 хувь байсныг 2024 онд 60.0 хувьд хүргэнэ. 2.3.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэн, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ. 2.5.Ирээдүйн эрүүл, идэвхтэй амьдралын хөгжлийг, баягйн спортыг дэмжсэн нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ. 2.6.Тэр бүл төвтэй хүний хөгжил”-ийг дэмжих, хүүхдэд ээлтэй аймаг болно. 2.9.Ахмадуудын идэвх, санаачилгатай ахлуудыг дэмжих, ажил, амьдралын туршлагыг нь залуу үед өвлүүлнэ. 3.1.Эдийн засгийн эрсдэлийг даван туулж, төсвийг тогтвортой байлгах боломжоо баримтлана. 3.2.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. 4.4. Ирээдүйн аюулгүй, амар тайван байдлыг хангана.	5.10.2.Олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй идэвхтэй хамтран ажиллаж, үр дүнтэй хэрэгжих буй төслүүдийг орон нутагт үргэлжлүүлэн дэмжих ажиллана. 3.1.5. Хүүхэд, залуучууд, ирээдэд уламжлалт өв соёл, ёс зүй, байгаль эколог, түүх, гадаад хэл, урлагийн боловсрол олгох, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. 3.4.3. Гэр бүл, хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, тэвчээгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэлт, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. 3.6.2.Ирээдүйг эгмт хэрэг, зөрчлөлд өртөх, хохирхоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. 3.6.5. Мал хулавйлах эгмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн малын бүтээ холбоодыг байгуулна.	4.2.Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бүхий л салбарт гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ. 4.4.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. 4.7.Аймгийн эрсдэлийг бууруулах замаар орон нутгийн ирээдүйн аюулгүй байдлыг хангах, гамшигтай тэмцэх чадавхийг нэмэгдүүлнэ.
	Нийт дүн	276			


Эх сурвалж: Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, ЗД-ын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, Дорнод аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө

1.2.3. Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт, ажлын байр бий болгох чиг үүргүүдийн хэрэгжилт 0.7-1.1 хувийг эзэлж байна.

ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн нийт 276 төсөл арга хэмжээг ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 4.2-т заасан чиг үүргийн хүрээнд төлөвлөж ажилласан байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээг ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 4.2-т заасан чиг үүргээр ангилан үзэхэд Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах чиг үүргийн хүрээнд нийт 84 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн нь нийт төсөл арга хэмжээний хамгийн өндөр хувь буюу 30.0 хувийг эзэлж байна. Харин Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт, ажлын байр бий болгох чиг үүргүүдийн хэрэгжилт 0.7-1.1 хувийг эзэлж байна.

Дүрслэл № 1 “ОНХС-ийн чиг үүргийн хэрэгжилт”



Эх сурвалж: аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн тайлан

1.2.4. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөөгүй 4 төсөл арга хэмжээ байна.

ОНХС-гийн төсвийн төслийг боловсруулах шалгуурууд болох Төрийн аудитын тухай хуулийн 6.3.2-т заасан бүрэн эрх, Төсвийн тухай хуулийн 29, 68 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-тай ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл арга хэмжээг тулган баталгаажуулахад:

Дорнод аймгийн 2021 оны ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аас баталснаас хойш зураг, төсөв, ажлын даалгаврыг хийлгэсэн 309.4 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. Жишиг гудамж төсөл эхлүүлэх /Хэрлэн сум/ 99.4 сая төгрөг,

2. Нийтийн орон сууцны барилгын дулаалга гадна фасадыг шинэчлэх /Хэрлэн сум/ 210.0 сая төгрөг

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх,” заалтын хүрээнд ирүүлсэн Дорнод аймгийн 2021 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлсэн. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх 1.5 тэрбум төгрөгийн 32 төсөл арга хэмжээг хууль, журамд нийцэхгүй арга хэмжээ тул хасах санал өгсөн. Үүнээс 289.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг 2021 оны ОНХС-гаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулсан байна.

1. Хэрлэн сумын 2, 3-р багийн өрхийн эмнэлгийн салбар шинээр барих 200.0 сая төгрөг,
2. Ахмад настнуудын чөлөөт цагийн төвийн байр /Хэрлэн сум, 10-р баг/ 89.0 сая төгрөг


БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтод үр дүн 70.7 хувьтай байна

2.1. ОНХС-гийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан ч худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

2.1.1 ОНХС-гийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны 6.0 хувийг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжих нийт 276 төсөл арга хэмжээнээс 216 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна. Үлдсэн 60 төсөл, арга хэмжээ нь худалдан авах ажиллагаа зохион байгуулах шаардлагагүй төсөл, арга хэмжээ байна. Худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтаар 38, харьцуулалтын аргаар 74, шууд худалдан авалтаар 85, олон нийтийн оролцоотойгоор 19 төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулсан байна.

Дүрслэл №2 “Худалдан авах ажиллагааны төрөл”



Эх сурвалж: Аймгийн худалдан авах ажиллагааны тайлан

1. Худалдан авах ажиллагааны баримт материалыг үзэхэд тендерт шаардлага хангахгүй оролцогчийг шалгаруулсан 2 тендер байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн “12.3.Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.” Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн “3.1.23.эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага” гэж эмийн сан, эрүүл

мэндийн байгууллага болон мал эмнэлгийг эм, эмнэлгийн хэрэгслээр бөөний үнээр хангах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;”, “11.1.1.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөлгүйгээр эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах;” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

1. Сувилахуйн тоног төхөөрөмж худалдан авах 40.0 сая төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл сонгон шалгаруулалтад нийт 10 аж ахуй нэгж оролцсон байна. Тендерийн баримт бичигт үнэлгээний хороо нь эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх шалгуур оруулаагүй байна. Үүнээс тендерийн баримт бичигт заасан /сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас багагүй байна., Нийт үнийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил, төстэй ажлыг 2019, 2020 онд хийж гүйцэтгэсэн байх/ шалгуур хангаагүй. өндөр үнийн санал ирүүлсэн “Иххалх нөмрөг” ХХК-ийг шалгаруулсан байна. Тус компани нь тендерийн баримт бичгийн эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тусгай зөвшөөрөлгүй байна.

2. Авто машины парк шинэчлэлт /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ - 336.0 сая төгрөгийн бараа нийлүүлэх тендерийн баримт бичигт заасан /нийт үнийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил, төстэй ажлыг 2019, 2020 онд хийж гүйцэтгэсэн байх/ шалгуурыг хангаагүй “Бат билэг гурван эрдэнэ” ХХК-ийг шалгаруулсан байна.

2. Худалдан авах ажиллагаа зохион байгуулах, үнэлэх журам, зааврыг мөрдөж ажиллаагүй дараах зөрчлүүд байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.1, болон Сангийн сайдын 2008 оны 249, 2012 оны 194 дүгээр тушаалаар батлагдсан тендер үнэлэх зааврыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

1. Төв замын гэрэлтүүлгийн шинэчлэл 30.0 сая төгрөгийн ажлын тендерийн баримт бичгийг үнэлгээний маягтаар үнэлээгүй.

2. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах 826.7 сая төгрөгийн ажлын тендерийн баримт бичгийг үнэлсэн үнэлгээний хорооны гишүүдийн гарын үсэг дутуу, техникийн санал үнэлсэн үнэлгээний маягт байхгүй,

3. Хөгжлийн төлөвлөгөө батлуулах /Гурванзагал сум/ 45.0 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээг үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийж, техникийн саналыг үнэлээгүй.

4. Нийтийн орон сууцны байрны их засвар /Хэрлэн сум 9-р баг, 10-р байр/ 245.0 сая төгрөгийн ажлын тендерийг дахин зарласан хурлын тэмдэглэл байхгүй.

5. Урд болон хойд төв зам дагуу гэрлийн шон, замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах 25.0 сая төгрөгийн ажилд тендерийг нийт 5 удаа зарласан “Их талын шуугиан” ХХК шалгарсан дахин зарласан тендерийн хурлын тэмдэглэл дутуу.

6. Аймгийн Татварын хэлтсийн урд автомашины зогсоолыг сайжруулах 20.0 сая төгрөгийн ажлыг 4 удаа зарласан баримт хурлын тэмдэглэл дутуу.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль мөрдөж ажиллаагүй дараах тохиолдлууд байна.

Тендер хүчинтэй байх хугацаа дууссаны дараа гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 24 дүгээр зүйлийн “24.5.Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 30 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Нийтийн орон сууцны барилгын дээврийн засвар /Хэрлэн сум, Халхгол сум/ 501.3 сая төгрөгийн ажлын тендер хүчинтэй байх хугацаанд зохион байгуулж дуусгаагүй байна.

Амжилтгүй болсон тендер шалгаруулалтыг 2 дахь удаагаа зарлахдаа хуульд заасны дагуу тендерийн бичиг баримтад өөрчлөлт оруулаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн “30 дугаар зүйлийн “30.4.1.тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Нийтийн орон сууцны байрны зоорины давхрын шугам сүлжээг засварлах / Хэрлэн сум, 9-р баг/ 130.0 сая төгрөгийн материал нийлүүлэх тендер шалгаруулалт 3 удаа зарлаж амжилтгүй болсон байна. Амжилтгүй болсон тендер шалгаруулалтыг 2 дахь удаагаа зарлахдаа хуульд заасны дагуу өөрчлөлт оруулж зарлаагүй байна.

Тэгш өрсөлдөх боломжийг хязгаарласан. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн “6.1.Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэсэн зарчмыг мөрдөж ажиллаагүй.

ЗДТГ-ын барилгын засвар /Чулуунхороот сум/ 48.7 сая төгрөгийн дээврийн засварын ажил дээр угсралт, өргөтгөл шинэчлэлийн тусгай зөвшөөрөл тавьж шалгуурыг өндөрсгөсөн,


Дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг тусад нь багц болгож зарлаагүй. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн “8.7.5.энэ хуулийн 10^{1.1}-д заасан дотоодын үйлдвэрээс авах боломжтой барааг импортын бараанаас тусад нь багцлах.” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, тохижилт 135.0 сая төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалт зарлахдаа дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг тусад нь багц болгож зарлаагүй.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасан зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн ОНХС-гийн 2021 оны хөрөнгөөр санхүүжүүлэх нийт 276 төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хууль болон сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-д заасан ОНХС-гийн хөрөнгийг зарцуулах чиг үүрэгт заасантай нийцсэн байна. Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтыг ангилан харуулбал.

Дүрслэл №3 “ОНХС-гийн зарцуулалт”






Эх сурвалж: аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн тайлан

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 70.7 хувийн үр дүнтэй байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс зорилтод түвшин, үр дүнд хүрээгүй 81 төсөл, арга хэмжээ байна.

Дорнод аймаг 2021 онд ОНХС-гийн хөрөнгөөр 276 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 15,431.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 195 төсөл, арга хэмжээнд 11,096,2 сая төгрөг зарцуулсан байна. Тайлант хугацаанд хэрэгжээгүй 81 төсөл арга хэмжээний шалтгааныг тулган баталгаажуулахад цаг үеийн нөхцөл байдлаас үүссэн хилийн хорио, бараа материалын үнийн өсөлт зэргийг тооцоолж төлөвлөөгүйгээс зарлагдсан 54 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй байна. Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээг аймаг, сумаар ялган харуулбал сумд 72 хувийг эзэлж байна.

Дүрслэлт 4 “Хэрэгжээгүй ТАХ”



2.2.2. ОНХС-гийн төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт 70.7 хувийн үр дүнтэй байна.

Дорнод аймаг 2021 онд ОНХС-гийн хөрөнгөөр 276 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. ОНХС-гийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн тоогоор нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. “Төсөл арга хэмжээний тоо, хэрэгжилт”

д/д	Нэрс	Төлөвлөгөө	Хэрэгжилт	Хувь
1	Аймаг	104	81	77.9
2	Баяндун	14	7	50.0
3	Баянтүмэн	14	10	71.4
4	Баян-Уул	12	6	50.0
5	Булган	8	4	50.0
6	Гурванзагал	5	1	20.0
7	Дашбалбар	9	7	77.8
8	Матад	18	17	94.4
9	Сэргэлэн	13	10	76.9
10	Халхгол	14	10	71.4
11	Хөлөнбуйр	10	9	90.0
12	Хэрлэн	12	9	75.0
13	Цагаан-Овоо	26	15	57.7
14	Чойбалсан	10	4	40.0
15	Чулуунхороот	7	5	71.4
	дүн	276	195	70.7

Эх сурвалж: аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, судалгаа

Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт 70.7 хувьтай байна.

Нийт төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний 29.3 хувь хэрэгжээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэж заасантай нийцэхгүй байна.

Орлогын эх үүсвэр нь оны эцэст бүрдсэнээс 22, цаг үеийн нөхцөл байдлаас үүссэн хилийн хорио, бараа материалын үнийн өсөлт зэрэгтэй холбоотой тендер шалгаруулалтыг зарласан боловч оролцогч ирээгүй 54, цар тахалтай холбоотойгоор сургалтын төлөвлөсөн арга хэмжээ хийгдээгүй 5 нийт 81 төсөл арга хэмжээ буюу 29.3 хувь хэрэгжээгүй байна.

2.3. ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтгүй хөрөнгө байна.

2.3.1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийт хөрөнгийн 2.3 хувь нь ашиглагдахгүй байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийт 148 төсөл арга хэмжээний 9,401.9 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч 56 байгууллага бүртгэж авсан байна.

Баян-Уул, Баянтүмэн, Хөлөнбуйр, Халхгол, Хэрлэн, Матад, Чойбалсан сумдад ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалтын байдлыг газар дээр нь үзэхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Баянтүмэн суманд “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах” 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил. Хүүхдийн тоглоомыг шинээр баригдаж буй цэцэрлэгийн гадна байрлуулахаар тооцож төлөвлөсөн ч барилга хугацаандаа ашиглалтад ороогүйгээс тоглоомуудыг суурилуулаагүй, Матад сумын “Мал нядалгааны цех” 120.0 сая төгрөгийн өртөгтэй он дамжиж хийгдсэн ажил. Хариуцан ажиллуулах орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байхгүйгээс, Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын авто машины парк шинэчлэлтээр 70.0 сая төгрөгөөр авсан төв болон туслах замын шороо шүүрдэгч 2 машин, 6.0 сая төгрөгийн цас, шороо цэвэрлэх, явган зам шүүрдэх техникүүд нь гадна зам талбай цэвэрлэх зориулалтгүй техникийн тодорхойлолт боловсруулж авсан зэргээс шалтгаалж ашиглагдахгүй байна.

2.3.2. Матад суманд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хамгаалалтгүй 2 хөрөнгө байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцахаар журамд заасан.

Матад сумын төвөөс 5 км зайтай хийгдсэн “Мал нядалгааны цех”, “Иргэдийн сургалт мэдээллийн хөгжлийн төв”-ийн барилгууд харуул хамгаалалтгүй байна.

БҮЛЭГ 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг тайлагнасан ч хяналтыг бүрэн тавьж ажиллаагүй байна.

3.1. Аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-гийн журамд заасан хяналтыг тавьж ажиллаагүй байна.

3.1.1 ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 51 хувьд ИТХ-аас хяналт тавьж ажиллаагүй байна.

ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлд Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” 9.4 -т заасны дагуу аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх хороо хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавьж ажиллахаар зохицуулсан.

Аудитаар аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд хяналт хэрэгжүүлсэн эсэхийг тулган баталгаажуулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 276 төсөл, арга хэмжээний 51 хувьд нь ИТХ-аас хяналт, тавьж ажиллаагүй байна.

Дүрслэл № 4 “ИТХ-аас ТАХ-д хийсэн хяналт”



Эх сурвалж: аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, хяналтын ажлын тайлан.

ИТХ-ын хяналт хангалтгүй байгаа нь аймгийн болон Баянтүмэн, Хэрлэн, Чойбалсан сумдын ИТХ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” 9.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс шалтгаалсан байна.

3.1.2. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.12-д “Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.” гэж заасны дагуу захиалагч байгууллагатай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д зааснаар төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийг хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгосон байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо тухайн төсөл, арга хэмжээг хянаж баталгаажуулсан гүйцэтгэлийн баримт, захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримт материал, хүлээн авсан комиссын дүгнэлт зэргийг үндэслэсэн байна.

3.1.3. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын байгууллагаас ОНХС-гийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар 2 төлбөрийн акт, зөрчил арилгуулах 5 албан шаардлага, 4 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

		Хүснэгт 6. “Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт”					
д/д	Зөрчлийн төрөл	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Хэрэгжилт хувь	Тоо	Хэрэгжилт хувь	Тоо	Хэрэгжилт хувь
1	Зориулалт бусаар зарцуулсан	1	100	-	-	-	-
2	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн	-	-	-	-	2	100
3	Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн	-	-	1	100	-	-
4	Гэрээний хугацаа хэтэрсэн алданги тооцоогүй	1	100	-	-	-	-
5	Дутуу буюу чанаргүй хийгдсэн	-	-	2	100	-	-
6	Бүртгэл тайланд тусгаагүй	-	-	1	100	-	-
7	Орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй	-	-	1	100	-	-
8	Захиалагчийн хяналт тавиагүй	-	-	-	-	1	100
9	ОНХС-гийн эх үүсвэр дэх хандив тусламжийн орлогыг бодитой төлөвлөөгүй	-	-	-	-	1	100
дүн		2	100	5	100	4	100

Эх сурвалж: Дорнод аймаг дахь ТАБ-ын 2021 оны жилийн эцсийн статистик мэдээ

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 оны аймгийн ОНХС-гийн төлөвлөлт, сумдын ОНХС-гийн 2020, 2021 оны хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна. Аудитаар хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой алдаа, зөрчлийг илрүүлж холбогдох байгууллага албан тушаалтанд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 9.5-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна.

3.2. Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг бүртгэж, тайлагнасан боловч, үр дүнгийн талаар ОНХС-гийн удирдлага мэдээллийн системд оруулж ажиллаагүй байна.

3.2.1 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Сумдын ЗДТГ нь ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 9.2-т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж ажилласан байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 9.9-д зааснаар ОНХС-гийн 2021 оны хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж 2022 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 5/543 дугаар албан бичгээр сангийн яаманд хүргүүлсэн байна.

Тайланд дараах мэдээллийг тусгахаар журамд заасан. Үүнд:

1. ОНХС-гийн тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр;
2. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр;
3. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа;
4. Шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн гэрэл зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт;
5. Он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт;
6. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал;
7. Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга мэдээллийг тусгаагүй байна.

3.2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 148 ширхэг 9,401.9 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна.

ОНХС-гийн хөрөнгө оруулалт, төсөл арга, хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг сумдын ИТХ-аар тогтоол гаргуулж холбогдох байгууллагуудын хөрөнгөд бүртгүүлсэн байна. Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийт 148 төсөл арга хэмжээний 9,401.9 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч 56 байгууллага бүртгэж авсан байна.

3.2.3. Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн төсөл арга, хэмжээний 51.1 хувийг ОНХС-гийн удирдлагын мэдээллийн системд мэдээлээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг ОНХС-гийн Удирдлага мэдээллийн системд байршуулж ажиллахаар заасан.

Аймаг, сумдын 2021 онд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг www.onhs.mof.gov.mn цахим сайтад байршуулсан эсэх горим сорил хэрэгжүүлэхэд:

ОНХС-гийн 2021 оны хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс, Гурванзагал, Цагаан-Овоо сумдын санхүүгийн алба ОНХС-гийн Удирдлага мэдээллийн системд мэдээлээгүй байна.

Энэ нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод үүрэгжүүлж өгөөгүйгээс орхигдсон байна.

3.2.4. Шилэн дансны цахим хуудсанд аймгийн 14 сумаас 2 сум ОНХС-гийн мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй байна.

ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1.1, 6.3.9 дэх заалтуудаар шилэн дансны shilendans.gov.mn цахим сайтад байршуулахаар тусгайлан зааж өгсөн байна. Шилэн дансны нэгдсэн цахим сайтад ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулж ажилласан эсэхийг тулган үзэхэд

Баяндун сум 2 дугаар сараас хойш, Булган сум 8 дугаар сараас хойш гүйцэтгэлийн талаарх мэдээлэл оруулаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1.1.1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

1.1.2. Аймгийн хэмжээнд 9 сум Малын тоо толгойн албан татвараас орох орлогыг төлөвлөж, батлаагүй байна.

1.2.1. ОНХС-гийн журамд заасан сумын төвөөс алслагдсан багаас ирүүлсэн хамгийн өндөр санал авсан төсөл арга хэмжээг ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад оруулаагүй 3 сум байна.

1.2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна.

1.2.3. Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт, ажлын байр бий болгох чиг үүргүүдийн хэрэгжилт 0.7-1.1 хувийг эзэлж байна.

1.2.4. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөөгүй 4 төсөл арга хэмжээ байна.

2.1.1 ОНХС-гийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны 6.0 хувийг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасан зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс зорилтод түвшин, үр дүнд хүрээгүй 81 төсөл, арга хэмжээ байна.

2.2.2. ОНХС-гийн төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт 70.7 хувийн үр дүнтэй байна.

2.3.1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийт хөрөнгийн 2.3 хувь нь ашиглагдахгүй байна.

2.3.2. Матад суманд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хамгаалалтгүй 2 хөрөнгө байна.

3.1.1 ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 51 хувьд ИТХ-аас хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1.2. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

3.1.3. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.2.1 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

3.2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 148 ширхэг 9,401.9 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна.

3.2.3. Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн төсөл арга, хэмжээний 51.1 хувийг ОНХС-гийн удирдлагын мэдээллийн системд мэдээлээгүй байна.

3.2.4. Шилэн дансны цахим хуудсанд аймгийн 14 сумаас 2 сум ОНХС-гийн мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, Факс: 7058-4584

2022.05.31 № 7/2226
танай -ны № -т

Г Тайлбар хүргүүлэх тухай Г

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

И. Санширмугу:

Машиндуг, саналог дахин
авч үүгч шийдвэрлэх саналаа
МАТ машиндуги, аудитор
дугаар

2/02
Болортуул

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны төсөл, арга хэмжээний бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-нд хийсэн аудитын тайлангийн дүгнэлт хэсгийн 2.2.1-т ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс зорилтод түвшин, үр дүнд хүрээгүй 81 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 23 төсөл, арга хэмжээнд дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. “Start up” төвөөр дамжуулан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг төсөл, арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлж дууссан.

2. “Жишиг гудамж төсөл эхлүүлэх (Хэрлэн сум)”, “Тугийн сүмийн төлөвлөлт, зураг төсөвт шинэчлэлт хийлгэх”, “Суурь өвчлөлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуны сувилалд хамруулах ажлыг үргэлжлүүлэх”, “Монгол экспорт хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг экспортлоход дэмжлэг үзүүлэх” төсөл, арга хэмжээ нь дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоож, бараа материалын хомсдол үүссэн мөн тайлант жилийн хугацаанд цар тахалтай холбоотойгоор төсвийн тодотгол хийж, нэн тэргүүнд эрүүл мэндийн салбарын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл шаардлага бий болсонтой холбоотойгоор хассан.

3. Бусад 18 төсөл, арга хэмжээ нь Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан удааширсан бөгөөд төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор 2023 оны төсөвт шилжүүлэн ажиллаж байна. Үүнээс “Нийтийн орон сууцны байрны зоорийн давхрын шугам сүлжээг засварлах (Хэрлэн сум, 9-р баг)”, “Хүүхдийн цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн тоноглол солих (Баяндун сум)”, “Халуун усны барилгуудын засвар, тоног төхөөрөмжийг шинэчлэх” ажлууд хэрэгжиж дууссан. Бусад 15 хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Ш.ЁЛ



010522537

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт:

1. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд журмын дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

- 1.Хууль, журамд заасан төлөвлөх шаардлагатай орлогын эх үүсвэрийг судалж, ИТХ-аар батлуулах.
- 2.ОНХС-гийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бий болгох зохион байгуулалтыг хийж ажиллах.
- 3.ОНХС-гийн журамд заасны дагуу хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлсний дараах ашиглалттай холбоотой асуудлыг тооцож төлөвлөж байх.
- 4.Төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулан баталж байх.
- 5.ОНХС-гийн удирдлага мэдээллийн системд төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг журамд заасны дагуу мэдээлж ажиллах.
- 6.Шилэн дансны цахим хуудсанд ОНХС-гийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТАБ-Д САНАЛ:

1. ОНХС-гийн Удирдлага мэдээллийн системд мэдээлэл оруулах мэргэжилтнийг тодорхой болгож, албан тушаалын тодорхойлолтоор үүрэгжүүлэх.
2. ОНХС-гаас олгох санхүүжилтийг Дорнод аймгийн ОНХС-д хууль, журмын дагуу хуваарилсан эсэхийг тооцох.

Аудитаар нийт 2,222.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн зөрчил арилгуулах 1,005.4 сая төгрөгийн 6 албан шаардлага, Баянхонгор аймаг дахь ТАБ-д 2 санал, 1,216.6 сая төгрөгийн 7 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар тавигдсан албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2023 оны 3 сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn